

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Отгоны Гэмбэл	Дугаар	L256
Оршин суугаа аймаг	Өмнөговь	Оршин суугаа сум	Цогтцэций сум
Төрсөн газар	Цогтцэций сум	Төрсөн он	1915
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Сайн бичигтийн хийд	Сүм хийдийн дугаар	ӨГЦЦ 040
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 15	Ярилцлага авсан хүн	Ц.Гантулга



Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Сайн бичигтийн хийд

Гантулга: Гэмбэл гуй бол Сайн бичигтийн хийд дээр шавилан сууж байсан , одоо 92 настай ийм сайхан бүүрал байна.

За Гэмбэл гуй өөрийгөө танилцуулна уу, ямар хийдэд хэдээс хэдэн оны хооронд хэдэн настайдаа шавилан суусан, аль хошуу нутгийн хүн бэ?

Гэмбэл: За би одоо 1915 оны зуны эхэн сарын шинийн нэгэнд гарсан юм гэнэ лээ.Ижий минь тэгж ярьдаг юм , тэгээд би Отгоны гуравдугаар хөвүүн болон төрөөд зургаан нас хүртээ аав, ээжийнхээ гар дээр амьдарч ажиллаж байгаад зургаан насандаа анх Сайн бичигтийн хийдэд шавилан ороод, Гарьдцэд гэдэг багшийн шавь болоод шавилан сууж байгаад, одоо эхэлж Тангад ном эхэлж үзээд тэгээд 1937 он хүртэл тэр Сайн бичигтийнхээ хийдэд лам болоод, хорин нэг хүртлээ тэнд лам арван таван жил болоод тэгээд байж байтал Ханбогдын партизан Ханддорж гэж ядуу зундангийн лам нар багш нар минь бүгд баригдаад явчихсан л даа.Тэгээд л ядуу зундангийн лам нар үйлдвэр , артел байгуулна гээд л ирээд хуралдуулаад анх тэгээд бид хорин зургаан банди нар анхан лам нарын гар үйлдвэрийн артел гэж байгуулаж, эхэлж ажиллаж байгаад 1939

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

онд Цэций суманд Сайн бичигтийн хийд дээрээс нүүгээд, 1938 онд цэций сумын төвд ирж байгуулагдаж байгаад тэгээд 1939 оны зургаан сард цэргийн албанд татагдаж зүүн хязгаарт явж байлаа. Анх намайг цэргийн хугацаанд очиж, зургаан сарын арван нэгэнд Өмнөговьос яваад, зургаан сарын хорин гурванд Баянтүмэн ороход өчигдөр өглөө Баянтүмнийг бөмбөгдсөн гэж тийм байдалтай байсөөн. Дарга нар юу гэж ярьдаг байсан бэ гэхлээр анги цэргүүд хээрийн сургуульд гарчихсан гэж бидэнд одоо бол бас нууцын байдалтайгаар тэгж танилцуулж...Бид нар одоо 6 сарын хорин гуравнаас 1945 оны хоёрдугаар сарын хорин хэдэнд цэргийн албанаас халагдаж дөчин зургаан онд би орон нутагтаа ирсэн хүн.Тэгээд орон нутагтаа ирээд гар үйлдвэрийнхээ ажилд татагдаад, гар үйлдвэрийнхээ ажлыг үргэлжлэн хийж байгаад тэгээд 1951 онд морь уургалаж байгаад гараа гэмтээчихээд үйлдвэрээсээ гараад тэгээд 1956 онд анх Их Шанхай нэгдэл гэж байгуулагдахад анхны гишүүнээр, хорин таван хүний бүрэлдэнхүүнтэйгээр анхны гишүүнээр элсэж байсан юм аа.За тэгээд тэр өдрөөс эхлээд би, тэр анхны хуралдаа туслах бригадын дарга гэдэг ажлыг хүлээж авч, баахан залуучуудтай, дандаа туслах бригад өвс ногоо түүх хадлан тариалан янз бүрийн ажлуудыг хийж явж байгаад...Тэгээд мянга есөн зуун дөчин бишээ, ...1939...Болж ажиллаж яваад, тэгээд үргэлжлэн ажилласаар 1990 он хүртэл хүүхэд багачуултайгаа одоо ингээд...Би одоо дөрвөн охинтой, зургаан хүүтэй арван багачуултай өнөөдөр одоо энх сайхан , ажиллаж амьдарч байна аа.Тэр сайн бичигтийн хийдийг бас олон жил ажиллаж амчдарч байсныхаа хувьд бол тэгээд нэг сум орондоо нэг хийд байгуулъя гэж санаад тэгээд бас орон нутгийнхаа хүмүүстэй ярьж байгаад тэгээд миний нэг ач болох Галсандорж гэж нэг хүн байсан юм.Тэр хоёулаа ярилцаж байгаад анх санаачилж энэ хийдийг байгуулахаар ярьсан.Тэгтэл Галсандорж маань нас барчихдаг. Тэгээд одоо энэ орон нутагт нэг Сосорын хүү Баатар гэж хүнийг , одоо нэг өвгөн бий. Тэрүүнийг түшиглэж, тэгээд нэг хийд байгуулаад одоо нэг дөрвөн жил болоод явж байна даа.Тэгээд өнөө болтол одоо яахав, бишгүй л сайн сайхан альныг нь ...

Гантулга: Нэрийг нь та хэлнэ үү?

Гэмбэл: Аа Ширээт ламын хийд гэж байсан юм.

Гантулга: Төвдөөр ер нь өөр нэртэй байсан үү?

Гэмбэл: Аан ?

Гантулга: Төвдөөр одоо энэ сумын төв дээр байгаа шиг Төвд нэртэй байсан үү?

Сайн бичигтийн хийд?

Гэмбэл: Сайн бичигтийн хийд үү?

Гантулга:Тийм. Төвд нэр нь?

Гэмбэл: Ер нь Сайн бичигтийн хийд Төвд нэр нь Ширээт ламын хийд гэж байсан юм. Энэ эзэн нь бол ширээт Жамъяндорж гэж хүн байсан юм.Ширээт Жамъяндоржийн хийд байсан юм.

Гантулга: Өөрөөр нэрлэдэг байсан уу, энэ хийдийг?

Гэмбэл: Ондоо нэрлэхгүй ээ.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Хэдий үед ямар хүн байгуулсан хийд вэ, хэдэн жил болсон хийд вэ,одоо эргээд бодоход одоогоос хэдэн жидийн өмнө баригдсан хийд бол?

Гэмбэл: Аа ер нь энэ долоон хувилгааны долоо дахь хувилгаан нь байсан юм.

Гантулга: Жамъяндорж нь уу?

Гэмбэл: Жамъяндорж. Тэгэх дээр ямар ч байсан, зүү гаруй хоёр шахуу жил болсон байлгүй.

Гантулга: Одоо энэ сүм хийд хуучин харъяаллаараа аль аймгийн аль хошуунд орох вэ?

Гэмбэл: Одоо хуучин харъяаллаараа бол Түшээт гүний хошууны...Одоо хийд дээ.

Гантулга: Одоо Сайн бичигтийн хийдийн газар усны нэриг нэрлэвэл, ямар ямар нэртэй газар ус байдаг вэ? Эргэн тойрон байдаг газрыг нь ?

Гэмбэл: За ер нь Их Шанх гэдэг уулын энгэрт, яг энгэр хормой дор нь байгуулагдсан хийд.За их Шанх гэдэг уул бол бид нарын их эрт дээрээс аваад хурдтай, одоо морь одоо их сонирхдог, одоо эрийн гурван наадам их хийдэг тийм газар. Өгөөмөр , Сөнгийн уул,Цагаан овоо , Цэций уул, Ар цагаан овоо гэсэн ийм овоонуудыг газрыг шүтэж явдаг ийм улс аа.

Гантулга: Тахидаг овоо , уул ус нь гэвэл?

Гэмбэл: Тийм.

Гантулга: Энэ саяны дурьдсан газрууд уу?

Гэмбэл: Тийм.

Гантулга: Мөн мөн.

Гэмбэл: Энэ Цагаан овоо, энэ Ар цагаан овоо, Өвөр цагаан овоо хоёр Цагаан овооо байдаг юм . Өгөөмөр гэж байдаг юм. Лүн гэж байдаг юм. Цэций гэж байдаг юм. Ийм таван газрыг сэргээж тахиж байгаа юм.Бичигт болвол дээр үед бол Их бага лусыг тахидаг байсан юм аа.Тэр ам нь одоо Баян овоо нутгийн наад талд.

Гантулга: Тахидаг хайрхан нь тиймээ?

Гэмбэл: Тийм.

Гантулга: Тахидаг рашаан хад нь ?

Гэмбэл: Рашаан хад нь за энэ Шанхын энгэрт Бушингийн рашаан, Агуйтын рашаан гээд Шанхын хэцээр бас жаал жаахан жижиг рашаанууд байсан. Ер нь одоо нэрлэвэл хоёр ч газар байгаа . Ийм байна.

Гантулга: Ер нь бол тийм араараа уултай, урдүүраа тэгш талтай газар юм уу, тиймээ?

Гэмбэл:Тийм . Говь. Говь хөвчийн зааг дээр байгаа юм.Урагшаа бол хийдээсээ урагшаа говь хөндий болдог. Аа хойд тал нь бол Шанхын хэц, Их шанх гэдэг газар энэ бол их дээр үеэс алдар цуутай, их хурдтай тийм газар шүү дээ. Шанх чинь тийм нутаг.

Гантулга: Ойролцоо одоо харилцаа холбоотой байсан сүм хийдийг одоо хуучин байснаар нь нэрлэвэл?

Гэмбэл: Аа Хошуу хийд, Олдохын хийд...Тэгээд л Эхэн заг, Сангийн далай за энэ мэтийн одоо ом хийдүүд...Долоон сүм ч байлаа. Одоо Баян-Овоогийн төв. За Налихын хийд ч гэж байсан юм даа, тэнд чинь тэгээд та нарын уржигдрын орсон газар чинь.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Энэ хийдүүдийн лам нар хоорондоо холхоо харилцаатай?

Гэмбэл: Аан бие биенээ хэснэ, хурна. Одоо цаг цагийнхаа хуралд явна, ирж очдог. Бие биенийдээ очиж хурдаг. Би гэхэд одоо энэ ухай, Хошуу хийдэд явж л байлаа, Далайн хуралд ч явж л байлаа, Долоон сүмд очиж хурж ч явлаа, Налихад ч очиж хурж л явсан хүн. Тийм, багадаа.

Гантулга: Энэ Сайн бичигтийн хийд шарын шашны хийд үү?

Гэмбэл: Тийм, Будда. Шарын шашин.

Гантулга: Аан шарын шашин Богд Чойнхор ваагийн шашин?

Гэмбэл: Тийм . Одоо уул нь энэ чинь гурван удаагийн үе болж байгаа юм ш дээ. Бурхан багшийн шашин гэж байгаа, тэгээд Богд Чойнхор ваагийн шашин, одоо арван дөрөвдүгээр далай ламын шашин гэж. Одоо энэ гурван үеэ одоо уламжилж яваа тийм шашин даа.

Гантулга: Энэ Сайн бичигтийн хийдийн гол цогчин дуган нь , ямар гол шүтээнтэй байсан бэ?

Гэмбэл: Гомбо сахиус.

Гантулга: Гомбо сахиус уу, ядам сахиус нь?

Гэмбэл: Ядам сахиус нь тэр Ширээт лам өөрөө улаан ядам сахидаг хүн байсан юм.

Гантулга: Аан за. Ядам саиус нь адилхан?

Гэмбэл: Адилхаан. За тэгээд л Гомбо , Лхам , Чойжоо арван сахиусыг одоо шүтдэг байсан юм. Арав байсан юм шүү дээ, Жигжид гэхихээд Гомбо, Гонгор, Чойжоо, Лхам, Намсрай, Жамсран, Шаш, Шанлин , Цамба гээд ийм арван хийд, арван уншлагатай, арван хангал гэдэг чинь энийг хэлдэг байсан юм.

Гантулга: Та цогчин дуганы лам байсан уу, дацангийн лам байсан уу?

Гэмбэл: би аль алинд л хурдаг. Би Дүйнхороос бусдад нь, Сайн бичигтийн хийдийн бусад хуралд нь цөмөөрөнд нь сууж байсан юм.

Гантулга: Цогчин хийдийн гол шүтээн нь бол Гомбо байна тиймээ?

Гэмбэл: Тийм ээ.

Гантулга: Тэгвэл одоо бусад дацангуудынх нь гол шүтээн гэвэл, таны сууж байсан?

Гэмбэл: Өө тэгээд л юу бий. Шан бий. Чойжоо бий. Жамсран бий.

Гантулга: Эд нар нь аль дацангуудынх нь сахиусууд вэ?

Гэмбэл: За тэгээд ер нь Сандуй, Дэмчиг, тэр юу нь бол тэр Сандичогсом гээд гурван юу байдаг юм. Тэрнийх нв сахиус бол Сандуй, Дэмчиг, Даанжиг гээд байсан юм. Тийм, жигжид. Тэгээд л байж байсан юм. Тийм л хурлуудтай , тэгээд л ламиран гүнриг олон юм хурна л даа.

Гантулга: Ер нь Сайн бичигтийн хийд хэдэн лам хуваргатай байсан бэ?

Гэмбэл: За цогчин бол хоёр зуу гаруй байнга л байна. За тэгээд өнөө дацан хурлаар чинь мянга гаруй сууж л байна шүү дээ. Гучин хоёр багантай , тийм цогчин дуган гэдэг нь тийм дугантай байсан юм.

Гантулга: Гучин хоёр баганатай?

Гэмбэл: Гучин хоёр багантай.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Мянган лам багтахаар?

Гэмбэл: Ээ мянга гаруй лам багтана. Гол хошуу хийд шиг л , тэр домын дамжаа, гавжийн дамжаа гэхээр чинь л цуглачихна шүү дээ. Энэ хавь ойрын лам нар чинь цөмөөрөө цуглаад , бөөгнөөд хурлаа хурдаг байлаа.

Гантулга: Хутагт, хувилгаан орон хийдийн эзэн нь ямар хүн байсан бэ? Эрдэмтэй том том лам нар , зурхайч эмч нар гэж улсууд нэрлэвэл?

Гэмбэл: За тэгээд түмний багш Ёндон лам гэж байсан юм , Ширээт ламын багш нь. Тэр Шаравжамцан гэдэг хүн байсан юм. Одоо энэ зураг нь бид нар шүтээд байгаа, энэ сууж байгаа зураг нь.

Гантулга: За зургийг нь авна аа.

Гэмбэл: За өөр Шаравжамцан. За уран Цэдэн гэж нэг гайхалтай уран хүн байлаа. Одоо ураг судар нь тийм удмын л урчууд. Одоо тэр болвол гайхамшигтай хүн байсан юм. Тэгээд л татагдаад л явчихсан , зайлуул.

Гантулга: Тэр гайхалтай бүтэсэн бүтээлээс нь нэрлэвэл ямар бүтээл байна?

Гэмбэл: Үгүй э, тэрүүнд ер нь бүтээгээгүй юм байхгүй. Бурхныг оёно, шууна, зурна, тэгээд одоо цаасаар чиг одоо хатаамал хийнэ, шавраар чиг...

Гантулга: Сийлнэ?

Гэмбэл: Сийлнэ. Үгүй тэр чинь бүх юмыг хийдэг тийм хүн байсан юм. Уран Цэдэн гэдэг хүн байсан юм.

Гантулга: Энэ нутгийн хүн үү?

Гэмбэл: Энэ нутгийн хүн.

Гантулга: Энэ Ёндон Шаравжамцан гуайгаас өөр одоо хутагт хувилгаан, тэр Ширээт ламынхаа тухай?

Гэмбэл: За Ширээт лам Жамъяндорж гуай. Тэрнээс өмнө Жүгдэрзангийн ширээт гэж байсан юм. За би тэгээд хоёр үеийг нь л хэлье, тэрнээс илүү цаадахыг нь тоолоод ...

Гантулга: Жүгдэр...?

Гэмбэл: Жүгдэр зангийн ширээт гэж тэр зургадугаар ширээт нь , энэ долдугаар ширээт нь байсан юм.

Гантулга: Өшөө эрдэмтэй том лам нар?

Гэмбэл: За эрдэмтэй лам нар бол олон байсан даа.

Гантулга: Тэгнэ дээ.

Гэмбэл: Олон байсан. Дандаа л одоо баригдаж, татагдаад л... сайн сайхан бидний багш нар чинь бараг хүний гарт орсон л доо. Тэгээд л гучин долоон оны намраас эхлээд л юу яачихсан юм, гучин зургаан оны намраас эхлээд л ...

Гантулга: Бариад л ?

Гэмбэл: Бариад эхэлсэн шүү дээ.

Гантулга: Төвд лам нар ирж байсан уу, том нэртэй лам ирж ...?

Гэмбэл: Ёндонцан гэгээн лам ирж байсан юм. Энэ Баруун гэгээн.

Гантулга: Ёндон...?

Гэмбэл: Ёндонцан. Ёндонцан гэгээн гэж их том , Баруун том лам байсан юм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Баруун зүгийн лам уу?

Гэмбэл: Тийм.

Гантулга: Тэр хүн ирж ном заадаг ?

Гэмбэл: Тийм. За тэгээд л Дагваа дооромбо, Гонгор дооромбо гээд л томчууд, одоо баруун чигийн том Чойрын удирдагч нар. Дан дооромбууд, их ч нэртэй.

Гантулга: Том маарамба, зийрэмбэ?

Гэмбэл: Нансран маарамба гэж ирж байсан.Тийм тийм том улсууд ирж байсан юм.

Гантулга: Дансран гэсэн үү?

Гэмбэл: Нансран.

Гантулга: Аан Нансран маарамба.

Гэмбэл: Дуулаа биз дээ?

Гантулга: Дуулсан юм байна.Олон оам нар, гэлэн сахилтай хүн олон байсан уу?

Гэмбэл: Өө гэлэн сахилтай хүн ер нь олон байсан. Би өөрөө өвчний учраас багадаа, хорин настайдаа гэлэн болсон хүн.Долоон лам сууж байж гэлэн болгодог юм.Би нэг ухаан мэдрэл хагасарч , яльгүй нэг тэр үед...Тэгээд юу яасан юм л даа, намайг гэлэн болгосон юм .Одоо манай багш энд сууж байна, тэр Ёндон ламын...

Гантулга: Нэртэй зурхайч, эмч?

Гэмбэл: Цэдэн гуай сайн зурхайч. Гомбожав зурхайч.

Гантулга: Цэдэн?

Гэмбэл: Тийм. Уран Цэдэн. За сүүлийн үед Цэдэнгийн шавь Жамбачойдор байсан юм.

Гантулга: Одоо нөгөө хүрээнд байсан уу?

Гэмбэл: Тийм.

Гантулга: Жамбаа зурхайч гээд байдаг байсан мөн үү?

Гэмбэл: Биш ээ биш. Энэ манай энд нөгөө юуны хийдэд байж байгаад, хүрээ ч орсон л доо.Тэр Сүрэн эд нартай нэг зиндаа байсан юм, тэр зиндааных нь улс гавж мавж л байсан.

Гантулга: Сайн бичигтийн хийдийн энэ хамба лам, ширээт лам, цорж , ловон, гэсгүй, унзад , даа лам нарыг нэрлэвэл? Таны үед байсан улсуудыг?

Гэмбэл: За цорж нь Гомбоэрин, Гомбоэрин цорж. За цогчин ловон Тайвандай. Жүдийн ловон гэдэг нь хэн байгаа юм...Цэдэн байгаа юм.Гомбожав гэдэг нь Найдангийн ловон.

Гантулга: Цэдэн гэсэн үү?

Гэмбэл: Тийм. Цэдэн гээч хүн.Уран Цэдэн гэдэг хүн чинь л лут хүн байсан юм даа.

Гантулга: Жүдийн ловон , өөр?

Гэмбэл: Аа Жүдийн ловон, Найдангийн лово. Мамбын ловон гээд олон бий л дээ.

Гэмбэл: Аа тэгнэ. Гэсгүй , унзад?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гэмбэл: Аа гэсгүй унзад гэвэл...Данзан унзад гэж байгаад сүүлдээ гэсгүй болсон. За тэгээд Лувсандорж, Норов за тэгээд л ...

Гантулга: Гэсгүй нар дандаа?

Гэмбэл: Гэсгүй нар.

Гантулга: Даа лам?

Гэмбэл: Даа лам гэдэг чинь Чойдорж, Гомбозов даа лам байсан юм. Тэр манай багш Гарьдцэд гэдэг хүн даа лам байсан юм . За тийм улсууд байсан юм. Дэвшиг Банзрагч гэж, Эрүү Санхай...

Гантулга: Энэ дандаа даамал уу?

Гэмбэл: Тиймээ, даамлууд

Гантулга: Дэвшиг Банзрагч гэсэн үү?

Гэмбэл: Тийм.

Гантулга: Нярав гэсэн тийм ээ?

Гэмбэл: Тийм, нярав. Цолхой Ёндон.За тэгээд цамын даа лам гэж Махвал гэж нэг лут хүн байсан.Тэр чинь хоёр өдрийн цамыг удирдаж зохион байгуулдаг.Махвал гэж ерэн хэдтэй нас барсан.

Гантулга: Та бол Дүйнхор дацангаас бусад дацанд бүгдийг нь хурсан?

Гэмбэл: Бүгдийг нь хурлаа.

Гантулга: Ер нь Бичигтийн хийдэд хэдэн сүм дуган, дацан , жас байсан бэ?

Гэмбэл: Арван гурван жас байсан юм. Би чинь тэр Чойрын унзадын туслах, гарайб хийж байсан хүн би. Чойрын гарайб.

Гантулга: Аан гадагч унзад?

Гэмбэл: Тийм. Гадагч унзад хийж байсан юм.Туслах нь байсан юм. Ер нь гайхагдаж байсан юм.

Гантулга: Дацангуудын нэрийг нэрлэвэл? Тус бүрдээ нэртэй байх үү?

Гэмбэл: Байлгүй дээ. Мамба дацан байна, Найдан дацан байна, Жүд дацан байна. За тэгээд л Ядам дацан, за тэгээд л цамын жас гээд л тэгээд л тэр чинв Дүйнхор дацан байна.

Гантулга: Зурхай?

Гэмбэл: Аан?

Гантулга: Мамба, Жүд , Ядам, Цамын жас , Дүйнхор гээд биччихлээ?

Гэмбэл: Тэр Найдан жас ч гээд байсан. Чойрын жас ч гэж байсан . Энэ Цаньд Чойрын ном сүүлдээ их хөгжиж байсан газар, манай энэ.Манай багш энэ Чой аграмба , Лодойчойдон аграмба гэж бидэнд ном зааж байсан одоо багш.

Гантулга: Хаанааас аграмба болж байсан юм бол ?

Гэмбэл: Хаана ?

Гантулга: Аграмбаа энчээнээ болчихдог байсан үү?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гэмбэл: Тэгэлгүй.Энд аграмбууд чинь болж байсан.Тэр Цэдэн гуай чинь өөрөө аграмба болж байсан хүн.Жүдийн шавь лав байсан.Тэгээд Лувсаншанлай гэж байсан.

Гантулга: Одоо энэ олон дацангууд чинь,Чойрын дацанд чинь Чойр?

Гэмбэл: Тийм.

Гантулга: Аа Жүдийн дацанд нь?

Гэмбэл: Жүд.

Гантулга: Эм зурхайд нь ?

Гэмбэл: Тэгээд л Санж, Чэгсэм одоо тэгээд л Ламиран, Гүнжүүр , Данжиг тийм юм хурна.Дэмчиг ч хурна. Тэгээд л Найданд Найдан хурна, Мамба дацанд Мамбаа хурна. Тэгээд л ...

Гантулга: Ламиран?

Гэмбэл: Аа Ламиран хурна.

Гантулга: Гүрэм, дором хийдэг байсан уу?

Гэмбэл: Гүрэм дором хийдэггүй байсан.Одоо тэр үед үү?

Гантулга: Тийм, тусгайлан одоо гүрэм дором хийдэг тимйм дацанд засал хийдэг байсан уу?

Гэмбэл: Байгаагүй.

Гантулга: Сүсэгтнүүд хувиарааа л лам дээр очоод л ?

Гэмбэл: Тийм, тэгээд ер нь тэр үед чинь мэргэд одоо юугаараа л ард түмэндээ...янз бүрийн аврал буувал тэр хийдээсээ л аль чадалтай хүнээрээ хийлгэчихдэг.

Гантулга: Цамын жасд ер нь уншдаг ном гэж байх уу, тусгайлан?

Гэмбэл: Аан байна байна. Тэр чинь цамын жас...

Гантулга: Юу хурах уу?

Гэмбэл: Тэр дэглэм...юу яадаг юм, Гэвшил гэж хурдаг юм.Тэгээд тэр...цамын гэвшил гэж байдаг юмаа. Тэгээд тэр чинь олон өдрийн дэг заадаг юм аа. Арван хэдэн өдрийн одоо тэр чамнах чамны одоо...

Гантулга: Дэг сургууль?

Гэмбэл: Тийм, дэг сургуулийг чинь арван хэдэн өдөр хийнэ шүү дээ.Тэгээд л тэнд чиг үсчээд байна даа.Тэгж л ...

Гантулга: Мамба дацанд бол...?

Гэмбэл: Тийм.

Гантулга: Маналаа л хурах уу?

Гэмбэл: Тийм. Маналаа хурна. Одоо тэр чинь юу шүү дээ. Ер нь Манал гэдэг чинь одоо оточ.

Гантулга: Тийм, оточ манал?

Гэмбэл: Тийм, оточ маналын, отчийг л дүүрлээ...Одоо эмнэлэг, анагаахын л ...

Гантулга: Жүд ший гэж байдаг биз дээ?

Гэмбэл: Тийм

Гантулга: Чойрын дацандаа болохоор ямар хурал хийх вэ? Сургууль ном?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гэмбэл: Аа Чойр болвол ер нь олон гоцоотой.Тэгээд Хадаг шидав, Елдэн Жамбрай, Дондонсалан Зунданжав тэгээд л Умсанжид, Задсанжид , Гаарамба гээд л .Тэгээд гавжийн юунд ордог юм даа.

Гантулга: Та аль хүртэл нь сураад больсон бэ?

Гэмбэл: Үгүй ээ, би чинь тэр дом хүртэл нь суучихсан хүн.Дороосоо...

Гантулга: Дом барина гэхээр яг яадаг байсан бэ, тэнд?

Гэмбэл: Аан хуруулна. Дом хуруулна. Домын дамжаа бариулна.

Гантулга: Тэгээд? Одоо өөр олон лам нарын өмнө шалгалт шүүлэг өгөх үү?

Гэмбэл: Шалгалт өгнө. Тэгээд одоо тэр чинь долоон цойнжид байдаг юм . Нэг дом хийхэд чинь. Тэгэхээр лам цойнжид, лхагва , жүш,тэгээд л дажнууд, хорины дом, есний дом, наймны дом гээд л долоон цойнжид. Тэгээд л тэр чинь унзад, гэсгүйгийн цойнжид нар нь байна л даа. Тэгээд жорвон гэж...

Гантулга: Одоо тэр шалгалтын л улсууд байх нь тиймээ?

Гэмбэл: Тиймээ тийм.Зохион байгуулах...

Гантулга: Лянх дом?

Гэмбэл: Эхлээд лянх хурна. Лянх мордоно.Үрээ цагаан морин дээр л мордоод...

Гантулга: Лянх мордоно гэхээр яг яадаг байсан юм бэ?

Гэмбэл: Зуны эхэн сарын шинийн таванд лянх морддог байсан юм.

Гантулга: Тэгээд тэр морь унаад явдаг нь ...?

Гэмбэл: Морь унаад л тэгээд л яваад л ...Тэгээд энэ өмнө очиж, тэр сайнбичигтийн өмнө нэг Хээрийн булаг гэж байдаг юм.Тэрэн дээр цан уншаад тэгээ ирээд гурван хоног тэр домынхоо уншлагыг уншина даа. Өдөр шөнөгүй.

Гантулга: Өдөр шөнөгүй?

Гэмбэл: Тийм.

Гантулга: Тэгээд дараа нь ...?

Гэмбэл: Тэгээд дараа нь Лам Цойнжид хуруулдаг бол Лам Цойнжидоо хуруулна.Чавуу хуруулдаг хүн Чавуугаа хуруулна.Жүш хуруулдаг хүн Жүшээ хуруулна. Тэгж байгаад л намар болоод ирэхлээр чинь зэрэг нөгөө хавь ойрын лам нар чинь цуглаад л домын дамжаагаа барина даа.

Гантулга: Тэгээд олоуулаа домоо бариад л ?

Гэмбэл: Тэгнэ.

Гантулга: Ном хаялцана?

Гэмбл: Тэгнэ.Ном хаялцана.

Гантулга: Олон хоног хаялцдаг байсан уу?

Гэмбэл: Аа ямар зүг байхав, гурван хоног...Гурван өдөр.

Гантулга: Тэгээд л дараа нь бүгд гэвш болцгооно?

Гэмбэл: Тэгнэ дээ. Дом л хийвэл гэвш болчихно.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Тэгээд зиндааны бичиг гэж бичүүлэх үү?

Гэмбэл: Аан?

Гантулга: Зиндааны бичиг гэж бичүүлэх үү? Нэрээ бичүүлдэг, одоо тимй зиндааны тийм...?

Гэмбэл: Байна байна.

Гантулга: Та хэддүгээрт нь байсан бэ?

Гэмбэл: Өө тэр чинь их олон. Хамгийн доод тал нь хадаг гэж бий.Тэгээд шидэв, юүлжин, жумбрай, дондонжуу, цолнам тэгээд долоо дахь дээр нь байсан хүн би.

Гантулга: Та дээрээс өөрийн зиндаадаа хэдэд зогсдог хүн байсан юм?

Гэмбэл: Аан?

Гантулга: Өөрийн зиндаандаа дээгүүр лам байсан үү?

Гэмбэл: Юу...

Гантулга: Анги лам байсан үү?

Гэмбэл: Тэгсэн юм.Ангид зогсож байсан юм.

Гантулга: Энэ зурхай, эмийн дацангуудад ямар ямар ном уншиж, ямар ямар шалгалт авдаг байсан бэ? Сургалт?

Гэмбэл: Энүүнд үү?

Гантулга: Эх зурхай?

Гэмбэл: зурхай нь үү?

Гантулга: Тийм, зурхай , эмнэлэг?

Гэмбэл: Аа эмнэлэг бол одоо Мамба дацан пагзад гэж ном байдаг юм.Тэрнийг л хурна даа, уншина. Тэр чинь одоо хоёр , гурван өдөр хурна. Тэгээд л нөгөө Отчил бурхнаа шүтдэг. Одоо эмнэлгийн эмийн бурхан шүү дээ, Отчил гэж.Тэгээд долоо, найм...за байз гурван, хоёр, тэрэн дээр гурав...за байз долоо гурав арав, арван нэг. Арван нэгэн суваргатай байж.

Гантулга: Ойролцоо адилхан жижиг суваргууд уу, одоо дундаа том...?

Гэмбэл: Тийм. Нэг нь л хамгийн том суварга байсан.Хийдийнхээ зүүн хойд, хамгийн зүүн хойд талд нь байсан юм.За тэгээд тэрний урд талд гурван суварга гэж арын хүрээний урд орой дээр гурван суварга байсан юм.Тэгээд өврийн хүрээн.ий хойд талд хоёр байсан юм.Тэрнээс баруун өмнө нь бас нэг хоёр байсан юм.

Гантулга: Дунд хүрээнд нь ?

Гэмбэл: Тийм, дунд хүрээнд нь .Ийм л суварганууд байсан юм.

Гантулга: Бодь суварганууд байсан уу, өөр суварганууд байсан үү?

Гэмбэл: Аа даа, жанчив чодов голдүү байсан юм.

Гантулга: Ном барладаг байсан үү?

Гэмбэл: Барална аа барална.

Гантулга: Ямар ном голчилж барлах вэ, ганжуур данжуур?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гэмбэл: Ганжуур данжуур үгүй ээ. Манай энд бол тэр юу л , Чойжидын одоо хошуу хийдийн бар энэ тэр гээд тардаг байсан юм л даа.Тэгээд л барлаад л багачууд хүүхдэд үзүүлнэ л дээ. Тэгээд л Хангал, Чойжид энэ тэрийн бар байна. Тэгээд л ер нь л энэ юу чинь болвол...бартай л даа.Одоо манай энд бас ганжуурын бар байсан юм аа.

Гантулга: Бичигтэд үү?

Гэмбэл: Үгүй ээ үгүй.

Гантулга: Хошуу хурал дээр үү?

Гэмбэл: Хошуу хийдэд ч ганжуурын бар байгаагүй ээ.Ганданд...

Гантулга: Гандан хийд хүрээнд?

Гэмбэл: Тийм. Хүрээнд...Богдын хүрээнд,Дашчоймболын хийд гэжж байсан юм.

Гантулга: Энэ Бичигтийн хийдийн зураг байгаа юу? Зурмал зураг нь , хүрээний гар зураг? Тухайн үедээ л хийсэн байх даа, одоо арын хүрээ, дунд хүрээ, өврийн хүрээ гээд?

Гэмбэл: Байхгүй ээ. Хүн авсан зураг бас ганц нэг хүнд байдаг л байсан юм.

Гантулга: Авсан фото зураг юм уу, эсвэл нөгөө одоо Дэмчиг гуай эд нарын зурсан шиг уран зураг байгаа юу?

Гэмбэл: Байсан юм аа, байсан юм. Тэр чинь муу шар Пүрэвд л байсан юм даа.Зурагчин шар Пүрэвд. Аа цогчин дуганд бол одоо цогчингоо хурна, арван хангалаа хурна.

Гантулга: Тэгээд л болоо?

Гэмбэл: Тийм. Юу гэдэг чинь одоо цогчин...гучин хоёр магтаалтай, найман ерөөлтэ, тэгээд олон цацлагануудтай нэг тийм боть ном ,Чойжид гэдэг чинь.За арван хангал болох дээр зэрэг жигжид ямандагтайгаа арван сахиус байна.Тэрнийг цээжилнэ. Тэгээд л хамгийн нэгдүгээр анхны ном чинь Чойжид үзнэ. Чойжидынхоо тэр боть номыг үзэж байж шүүлгэх зүг эргэнэ. Зүг эргэнэ гэдэг юм.

Гантулга: Шалгалт.

Гэмбэл: Шалгалт өгнө.Тэрнийг уншихвал одоо тэгээд Чойжидтой боллоо гэнэ.Тэр арван хангалыг уншихвал арван хангалтай.Хангал , Чойжид хоёртой боллоо гэнэ.За тэгээд Ламиран, Гүнриг, Данжиг, Сандуйжад цугааранг нь цээжээд дандаа зүг эргэнэ.Шүүлгэнэ, шүүлгэж л батлуулна .Тэгээд суух эрхтэй болно.

Гантулга: Хуралд суух?

Гэмбэл: Хуралд суух.

Гантулга: Сарын хурал, шинийн найм, арван, арван таван ,хорин таван, хорин есөнд ямар ном хурдаг байсан бэ?

Гэмбэл: За ер нь өвлийн адаг сарын шинийн хорин есөнд бол Бүхзордог, Ягаан ярж...Энэ хорин, өвлийн адаг сарын хорин тавны орой Жанлав хураад, хорин таван, зургаан, долоон, найман, есөн гээд дөрвөн өдрийн сахиус хурдаг байлаа. Хүдэр гэж хурдаг. Тэгээд битүүний шөнө лхамаа яамалдаг.Өглөө цэдэр хурдаг, даанлав өргөдөг.Тэгээд золгодог.Тийм юм байлаа.Сайн бичигтэд...

Гантулга: Өөл бусад саруудад, энэ зужы, намрын саруудад?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гэмбэл: Намрын хурал, аа зуны маани уншина.Маани одоо зуны эхэн сард байна.Намрын маани хурна. Намрын хурал Чойжид байна.Аа хавар болохлээр чинь арван таван хоногийн ерөөл Жонёончид гардаг , мнай энд чинь.Сайн бичигтэд. Жонёончид гэж нэг сайхан юм нэг шөнө гараад өнгөрдөг.Тэгээд тэрнийг чинь Чоймбилж гуайн арван таван хоног гэдэг чинь одоо ч мөрдөж байгаа, шинийн нэгнээс хойш арван зургааныг хүртэл тасралтгүй хуралтай.Энэ болвол арван тавны ерөөл гэж ярьдаг юм.

Гантулга: Жилдээ нэг болдог хурал?

Гэмбэл: аан?

Гантулга: Жилдээ ганцхан болдог том хурал?

Гэмбэл: Жилдээ том болдог хурал ер нь гавж , домын дамжаа даа.Тэгээд ламиран , гүнриг бол ерөөсөө дөрвөн улиралдаа хурчихна шүү дээ.

Гантулга: Цам гардаг байсан гэж байгаа тиймээ?

Гэмбэл: Тийм,намрын .

Гантулга: Намрын...?

Гэмбэл: Намрын дунд сарын арван нэгэн , арван хоёронд.

Гантулга: Хоёр өдөр тийм ээ?

Гэмбэл: Тийм ээ тийм.

Гантулга: Их бага цам?

Гэмбэл: Тийм.

Гантулга: Олон багтай.

Гэмбэл: Тийм. Чойжидоо хурдаг.

Гантулга: Зүүн хэдэн багтай гэж байлаа? Зүүн хориод багтай гэлүү?

Гэмбэл: Тийм. Зүүн хориод, их цамын өдөр л зүүн хориод баг өмсөөд л ...

Гантулга: Бага цамын өдөр өө?

Гэмбэл: Бага цамын өдөр нэг зуугаад.Тэгээд тэр чинь манай чинь өнөө Гомбо сахиус шүтдэг байсан болоод далан. Таван махгал гэж далан таван баг байгаа юм шүү дээ.За тэгээд л дээр нь нөгөө туслах юунууд олон байна.

Гантулга : Таныг сахил хүртсэн үед бол цам гардаг л байсан уу?

Гэмбэл: Аа гарч байсан.

Гантулга: Жил бүр гарах уу, жилдээ хэд хэд гарах уу?

Гэмбэл: Аан жилдээ л нэг гарна.

Гантулга: Майдар эргэнэ биз дээ.

Гэмбэл: Майдар эргэнэ ээ , хавар.

Гантулга: Хэдэн өдөр эргэх үү, яаж эргэх үү?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гэмбэл: Нэг өдөр эргэнэ ээ. Өнөө морины нэг ногоон толгой байдаг юм, Майдар бурхан гэж.Тэгээд морины толгой хадгаар оосорлоод л тэргэн дээр хөшөөчихөөд, тэргээ хөтлөөд түрээд тэгээд эргэчихнэ.Гороо том оо, Сайн бичигтийн горошо гэдэг чинь чухам том гороо.Гурван хүрээ байсан юм. Гурван горооны...

Гантулга: Өвөр дээр?

Гэмбэл: Тийм. Тийм хийд байсан юм.

Гантулга: Ганжуур эргэдэг байсан уу?

Гэмыбэл: Эргэлгүй яахав.

Гантулга: Лам нар нь эргэх үү, хошуу ганжуур гэж энэ тэр эргэх үү?

Гэмбэл: Өө ганжуурыг чинь бол дээр үед сүсэгтэн олон л эргэнэ.Өөрснөө ч эргэнэ.

Гантулга: Аа бас эргэнэ?

Гэмбэл: Тэгнэ. Ганжуураа бариад дуган тойроод ч эргэнэ.Аа бүр гурвуулангийн тойроод эргэнэ.

Гантулга: Хошууныхаа хилийн зэсээр явдаг байсан уу? Олон хоногоор?

Гэмбэл: Аан?

Гантулга: Хошууныхаа хилийн зэсээр олон хоног явдаг байсан уу, ингээд тэмээнд ачааллаад явдаг байсан уу, ганжуур хошуу эргэнэ гээд?

Гэмбэл: Үгүй ээ үгүй.

Гантулга: Тэгж эргэдэггүй байсан уу?

Гэмбэл: Тийм яваагүй. Тэгж яваагүй юм.манай Сайн бичигт болвол тэгж яваагүй.

Гантулга: Цагаан сарын хурал яаж хурдаг байсан юм бэ, зуны адаг сарын хэднээс эхэлдэг , шинийн арван таван хүртэл ямар ямар ном уншдаг байсан бэ?

Гэмбэл: Ерөөл л хурна, голцуу. Чойижд , гучин хоёр магтаал уншина.Тэгээд өглөө цардим, өдөр гүнж, орой манлан тэгээд гурав таслаад хурчихдаг.Орой манланаа уншина, өдөр магтаалаа уншина сүй ганзалаа өргөнө, өглөө болвол дархиа хурна , цогшчингоо уншина, цардим гэж хурдаг тийм байлаа.

Гантулга: Өвлийн адаг сарын хэднээс эхэлдэг байсан, хорин хэднээс эхэлдэг байсан, цагаан сарын хурал?

Гэмыэл: Цагаан сарын хурал уу?

Гантулга: Тийм.

Гэмбэл: Хорин тавнаас эхэлнэ.

Гантулга: Тэгээд л хойшоогоо хурсаар байгаад л ...?

Гэмбэл: Тэгээд л хураа байгаад л лхамаа яамална.Тэгээд л өглөө цэдэр хурна, даараг өргөнө, тэгээд л золгоно доо.

Гантулга: Тэгээд сор залдаг байсан уу?

Гэмбэл: Зална аа. Хорин есөнд, тэр чинь хорин есөнд урд жилийнхээ бүх л муу юмыг гаргаж сороо залдаг байсан юм.

Гантулга: Яаж залдаг байсан юм, одоо яг тэр үед?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гэмбэл: Аа одоо цаасаар хийгээд , их том суварга хийгээд дөрвөлжин модон суурьтай.Тэгээд тэрнийг өргөөд, тэгээд галаар түлж, их том түлш хийж байгаад тэгээд Догдовжир уншаад хурал ...нөгөө балбаж нүдэж байгаад л тэгээд л цогчин , ловон байна уу, цорж нь байна уу тэр сорыг зална даа.

Гантулга: Бурхан багшийн дүйчэн өдөр, Богд ламын дүйчэн өдрөөр ямар ном хурдаг байсан бэ?

Гэмбэл:Аан?

Гантулга: Бурхан багшийн дүйчэн өдөр, Богд ламын дүйчэн өдрөөр ямар хурал хурдаг байсан бэ?

Гэмбэл: Одоо тэр намрын хурал, тэр цогчингоор хураад байгаа хурал чинь л дандаа л ер нь дээдсээ юу яасан хурлууд шүү дээ.

Гантулга: Магтаал эд нар уу?

Гэмбэл: Тийм.Цагийн хурал.Цаг гэдэг чинь л тэр үед юу шаардлагатай байсан тэрүүнийг л хурдаг.

Гантулга: Хайлан хурдаг байсан уу?

Гэмбэл: Хурна аа. Дөчин таван хоног.

Гантулга: Хэдийнээс хэдий хүртэл?

Гэмбэл: Аан?

Гантулга: Хэдийд, зуны сардаа хурдаг байсан уу?

Гэмбэл: Тэгнэ. Зуны сардаа дөчин тав хоног Хайлан хийнэ.

Гантулга: Олон лам хурах уу?

Гэмбэл: Гэлэн, гэцэл.

Гантулга: Дан гэлэг гэцэл нар уу?

Гэмбэл: Тэгнэ. Тэгэхдээ бол манайх жилдээ нэг хайлан хийхэд бол гэцэл, гэлэн нийлсэн нэг дал наян лам элбэг сууна.

Гантулга: Нүгнээ сахидаг байсан уу?

Гэмбэл: Сахина аа сахина.

Гантулга: Нүгнээ сахина гэж яадаг байса юм бэ?

Гэмбэл: Нүгнээ сахина гэдэг чинь одоо мацаг барьж, бие биендээ дуугардаггүй, ярьдаггүй, хурдаггүй өдөр ч байна.Одоо тэгж л нүгнээгээ сахидаг байсан юм.Нүгнээний дуган ч гэж байлаа, ярын дуган ч гэж байлаа.Тэр чинь хайлан хийдэг дуган. Яр хайлан гэж.Тэгээд хайлан жас ч гэж байлаа, нүгнээ жас ч гэж байлаа. Тэр чинь нүгнээ хурдаг.

Гантулга: Нөгөө арван гурван дуган жас гэж байсан гэсэн. Тэд нарыг яг нэг бүрээр нь нэрлэвэл?

Гэмбэл: Өө одоо тэгээд л ...

Гантулга: Ярынх?

Гэмбэл: Тийм, Ярынх, Нүгнээнийх, Дүйхорынх, Чамынх, Мамбынх, Найдангийнх, Чойрынх за тэгээд л Цогчин тэгээд л Жүд гэдэг чинь л тэр Жүдийнхээ юүнд бол Ламиран, Гүнриг, Данжир, Сандуй, Санжчогсом бүрэн хурдаг байсан юм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Жүд, Дүйнхор хоёр нь нэг байсан юм уу, тусдаа байсан юм уу?

Гэмбэл: Дүйнхор нь тусгай.

Гантулга: Энэ дацангуудад өдөр тутмын хурал нь бол өөр байх уу, хоорондоо?

Гэмбэл: Өөр өөр.

Гантулга: Жишээ нь Чойрынх нь?

Гэмбэл: Аан?

Гэмбэл: Жишээлбэл Чойрын дацан нь бол?

Гэмбэл: Чойр болвол дөрвөн улиралд хурна.Хаврын Чойр, зуны Чойр, намрын Чойр, өвлийн Чойр гэж дөрвөн улирлаар хурна.

Гантулга: Жүд бол?

Гэмбэл: Жүд болохлээр за ер нь улирал улиралд л шахуу хурдаг байсан байх л даа. Тухайн Жүдийн жасд чинь Сандуй хурна, Гүнриг хурна, Ламиран хурна, Данжиг хурна, Дэмчиг хурна.Тэгдэг байсан юм даа.

Гантулга: Мамбадаа?

Гэмбэл: Мамбадаа бол мамбаа л хурна.

Гантулга: Дүйнхордаа?

Гэмбэл: Дүйнхордоо дүйнхороо л хурна.

Гантулга: Найдандаа?

Гэмбэл: Дүйнхор чинь цагартай, чогортой.Бас чантай шүү.

Гантулга: Тэр хайлангийнхаа дацанд бол хайлан хурахдаа л хурна биз дээ, тиймээ?

Гэмбэл: Тэгнэ.

Гантулга: Бусад үедээ тэгээд л ...?

Гэмбэл: Нэг дөчин тав хоног жинхэнэ шавь хувцастай одоо гэлэн гэцэл гэсэн одоо тэр сахилынхаа эрэмбээр сууна.

Гантулга: Энэ дацангууд чинь одоо жилдээ болдог том том наадамтай хурал хийдэг байсан уу? Энэ Байшинтын хийд дээр ер нь том наадам зохиож хурдаг, шашны баяр?

Гэмбэл: Шашны баяр уу?

Гантулга: Тийм. Одоо дараа нь наадам хийдэг?

Гэмбэл: Одоо овоондоо л наадам хийнэ.

Гантулга: Овоондоо л наадам хийх үү?

Гэмбэл: Тийм. Овоо тахихдаа л наадмаа хийнэ. За тэгээд сүм хийдийн чинь хурал наадам гэдэг нь одоо тэр жүжиг юу үзээд л цам гарах, цагар, чугар, их бага чам гарах гээд л одоо Бичигтэд чинь олон янзын юм байна л даа.

Гантулга: Дацан дугангууд нь бол ямар материалаар хийсэн байсан бэ, тоосгоор үү?

Гэмбэл: Тоосго тоосго. Дан тоосго.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Дандаа хятад тоосго, зөн тоосго?

Гэмбэл: Зөн тоосго.

Гантулга: Сүм оротой юу, эсвэл модон...?

Гэмбэл: Сүм сүм. Дандаа одоо энэ ганжиртай, жанцантай дуган болгон тийм. Цогчин дуган л хамгийн урт юутай, гучин хоёр баганатай тийм том дуган байсан юм.

Гантулга: Хоёр давхар тийм өндөр байсан уу, дан нэг давхар байсан уу?

Гэмбэл: Нэг дан: Аа харин тэр дээдэх орой нь бол давхартай.

Гантулга: Дөрвөлжин дуган, дацангууд байсан уу, дан дугуй гэр хулбэрийн байсан уу?

Гэмбэл: Үгүй ээ, дөрвөлжин. Гонзгой дөрвөлжин янз бүр л дээ. Ер нь голцуул дөрвөлжин.

Гантулга: Энэ хийд ер нь дуган дацан, таныг шавь болсноос хойш шинээр нэмэгдэж барьсан дуган дацан бий юу?

Гэмбэл: Байлгүй дээ.

Гантулга: Жишээлбэл?

Гэмбэл: Одоо тэгээд л ...Одоо үеийнх ч яахав дэ, энэний чинь бүр шинэ юм.Зүгээр тэр үед чинь бол намайг юу яаж байхад бол шин хуучин дуган нүүж барьж одоо нүүж л байсан л даа.

Гантулга: Энэ байшин барилгыг нь Хятадууд авчирч бариулдаг байсан юмуу, зүгээр хоорондоо...?

Гэмбэл: Хятад авчирч бариулна.

Гантулга: Аа Хятадууд, барилгын Хятадууд?

Гэмбэл: Барилгын Хятад.

Гантулга: Байран суурин байх уу?

Гэмбэл: Өө эндээ шохойгоо чгаргана, зөнгөө ч гаргана.Тэр чинь хйдүүд чинь зүгээр орчиндоо л гурав дөрвөн бааюутай.Бичигт гэхэд чинь тав, зургаан бааюу бий.

Гантулга: Тоосгоных?

Гэмбэл: Тал бүрт нь. Тоосгоных, шохойных тэгээд олон бааюу бий л дээ.

Гантулга: Энэ дуган дацангууд гадуураа өнгө нь будагтай байсан уу?

Гэмбэл: Будагтай байна.

Гантулга: Дан шохой юу, өнгө нь?

Гэмбэл: За даа, голцуу цэнхэртэй байна.Нээх буддаггүй байсан юм аа.Одоо тоосгоныхоо өнгөөр л ...Дандаа цэнхэр, хөхдүү байдаг байсан юм.Хятад чинь хөх тууший цохидог, улаан тууший цохидоггүй тийм байсан юм.

Гантулга: Гүнчин ишчааны байсан гэсэн тиймээ?

Гэмбэл: Тэгсэн.

Гантулга: Хэдэн зиндаатай байсан бэ, таны үед?

Гэмбэл: Аан?

Гантулга: Чойрын дацан нь хэдэн зиндаатай байсан бэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гэмбэл: За байз долоо, найм, ес...Арав.

Гантулга: Арван зиндаатай?

Гэмбэл: Тийм.

Гантулга: Зиндаа тус бүр нь хэдэн жил сурдаг байсан бэ?

Гэмбэл: За нэг гурван жилтэй л ...

Гантулга: Тэгээд л нэг зиндаа?

Гэмбэл: Тийм.

Гантулга: Энэ бусад хийдтэй, Сангийн далай, энэ Хошуу хуралтай лам нараа солилцдог байсан, ном хаялцдаг байсан өөр ямар харилцаа холбоотой байсан бэ?

Гэмбэл: Хурлаа хурна. Мөн цагийн хурал ирж хурцгаана.Аа Цаньд Чойрынх бол бүр одоо бөөгнөрдөг.

Гантулга: Ном хаялцана?

Гэмбэл:Газар бүрээс ирж цуглана.

Гантулга: Тэгээд л хэсээд л ном уншчихаад явна?

Гэмбэл: Тийм. Гандан, Дашчоймболоос чиг л ирж л байна.Өлгий хийдээс чиг л , Өлгий хийд чинь их гэвштэй байсан даа.Өлгий хийд чинь олон гэвштэй байсан газар.

Гантулга: Тэр Олдохын хийд гэж бас их олон гэвштэй газар байсан уу?

Гэмбэл: Тэгсэн.Олон гавж нар олон гэвштэй байсан.

Гантулга: Сайчууд?

Гэмбэл: Сайчууд. Тэр Хошуу хийд чинь Онгийн голын хийд байсан юм.Тэр Олдохын хйд чинь энэ Цогтовоогоос хойш Хулт хоёрын хооронд байдаг юм ш дээ. Яг талдаа...

Гантулга: Тэр Сайн бичигтийн хийдээс Төвд , Энэтхэг рүү лам ном сурахаар явдаг байсан уу?

Гэмбэл: Бишгүй явж байсан.

Гантулга: Аль дацанд очдог байсан, Төвд рүү?

Гэмбэл: Аа тэгээд л голцуу юу яаж байсан юм даа...Өнөө Лавранд явж байсан, Зууд явж байсан.

Гантулга: Баруун Зууд?

Гэмбэл: Тийм, Баруун зууд.Тэгээд ингэж л явна даа.

Гантулга: Энэ том ширээт лам нь бол Төвдийн том хутагт хувилгаадтай холбоо харилцаатай байсан уу, ирж очиж байсан уу?

Гэмбэл: Аа ирж очно, холбоотой. Тэр үед тийм холбоо, яриа хөөрөө...

Гантулга: Ламын холбоо?

Гэмбэл: Тийм, холбоотой.

Гантулга: Эргэл мөргөлөөр улсууд их явдаг байсан уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гэмбэл: Явдаг байсан.Одоо эндээс чинь л Довончомбод мөргөнө, Утайд мөргөнө, Гүмбэнд мөргөнө гээд л явна.Жанжхүү Ванчин Богдод мөргөнө гээд л ...Одоо тухай нь болвол, жишээ нь бол тэгж явна л даа. За тэгээд Богдын хүрээ явна, Богд Жавзандамба хутагтад мөргөнө.Одоо тэгээд л ...

Гантулга: Энэ олон дацангууд чинь тус бүрдээ жастай байсан байх тиймээ?

Гэмбэл: Ердөө цугаараа жастай.

Гантулга: Олон жастай байсан уу?

Гэмбэл: Олон жастай байсан.

Гантулга: Тэр арван хэдэн дуган тус бүрдээ жастай байсан уу?

Гэмбэл: Жастай жастай.

Гантулга: Малын тоо толгой баян жас байсан уу?

Гэмбэл: Баян баян.Тэр үе чинь одоо өнөө ямар нөгөө төсөв төлөвлөгөө байх биш дээ. Дандаа л нөгөө жандаг, өглөгийн ид шидээр л бүрдсэн хурал байна, малтай болчихсон. Аа гүү барьчихсан ч байна, жас чинь.Өө тэмээ уячихсан ч байж байдаг, үхэр тугал зэллэчихсэн ч байж байдаг.Хонь ямаа холбоод сааж байна.Тийм л баян баян жасууд байсан юм.

Гантулга: Хийдийн лам нар хийд дээрээ, хийдээ тойроод л гэр байшинд амьдрах уу?

Гэмбэл: Тэгнэ. Дандаа л гэр байна даа.

Гантулга: Баян ч байна, ядуу я байна тийм ээ?

Гэмбэл: Тэгнэ.

Гантулга: Баян нь бол тэгээд л хашаа байшин...?

Гэмбэл: Өө байшингүй ч айл гэж бараг байхгүй.

Гантулга: Байшингүй айл гэж бараг байхгүй?

Гэмбэл: Тийм.

Гантулга: Ихэвчлэн л байшинд?

Гэмбэл: Тийм. Байшинд...

Гантулга: Зун нь байшиндаа суух уу, өвөл зунгүй...?

Гэмбэл: Тэгнэ. Өвөл нь гэртээ сууна.

Гантулга: Өвөл нь гэртээ, зун нь байшиндаа ?

Гэмбэл: Тийм.

Гантулга: Одоо хүрээнийх шиг тийм олон аймгууд байсан уу, тэдний аймаг, эдний аймаг гээд одоо Сайн Бичигт дээр?

Гэмбэл: Байхгүй. Аймаг гэж байгаагүй. Гурван хүрээ л гэж байсан юм.Ар хүрээ, дунд хүрээ, өвөр хүрээ л гэж гурван хүрээгээр л тэр юу болж байсан юм.

Гантулга: Цож лүйжингийн лам нар байсан уу?

Гэмбэл: Байсан байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Ямар ямар хүмүүс байсан бэ?

Гэмбэл: Тэр Тайвандээ гэж ловон байна. Тэр лут сайн цож байсан юм .Сайн хүн байсан юм.

Гантулга: Өөр хийдээс гадуур ойрхон ирдэг цож лүйжингийн улсууд байх уу?

Гэмбэл: Энд одоо Борын Данзан гэж хүн байж байгаад, цож хүн байж байгаад саяхан нас барчихлаа.Хөдөөний малчин хүн байсан юм.Тэр цож хүн байсан хүн юм аа.Тэр бол аргагүй энэ юунд Ханбогдын хаданд очиж жарз хийсэн. Жинхэнэ жарзын л юу л даа.

Гантулга: Одоо энэ Сайнбичигтийн хийдийн цож лүйжингүүд бол тэр газраа очиж хийдэг байсан юм уу?

Гэмбэл: Тэгнэ ээ тэгнэ.

Гантулга: Тийм хүн тавьдаг газар юмуу?

Гэмбэл: Үгүй ээ, хүн хаданд сууж нямба хийдэг.

Гантулга: Энэ цож лүйжин улсууд чинь олон үхээрийн газар юмаар тойрдог гэж...?

Гэмбэл: Тэгнэ тэгнэ. Тэрүүгээр явна. Аль л хүнд газраар тэр юугаа хийж чадаж байна уу гэдгээ шалгаж ,шалгаруулж байгаа юм. Ухаан нь дээр үед бол чөтгөр, мөтгөртэй тийм газраар их явуулна.Тэнд аваачиж лүйжин тавиулна, гүйдэлтэй газраар.Тэгээд тэрнийг ялж чадаж байвал чи одоо сая сурж гэж үнэлэлт өгнө. Цож гэдэг чинь тэр юм шүү дээ.

Гантулга: Эмэгтэй хандмаа лам нар байсан уу?

Гэмбэл: Аа даа, эмэгтэй хандмаа лам нар ч гэж бараг байгаагүй шахуу даа. Сүүлийн үед энэ Манлай сумын нэг хөгшин Дунсран гэж байгаад тэр энэ бас жаахан юм оролдож байгаад тэгээд нас барчихлаа.

Гантулга: Та одоо банди байхдаа багшийнхаа гэрт байсан уу, тусгайдаа ах нартайгаа байсан уу?

Гэмбэл: Багштайгаа. Яг багшийн гар дээр аваачаад хаячихсан.

Гантулга: Өглөө эрт унтаж сэрээд л боссоноосоо хойш орой унтах хүрлээ юу хийдэг байсан , тэрийг нэг ярьж өгөөч? Өдөр тутмынхаа амьдралын юмыг...?

Гэмбэл: Үгүй одоо , өглөө босоод л галлаад л цайгаа уугаад л , өглөө мөргөчихөөд л өдрийнхөө заалгасан номыг цээжилж багшдаа шүүлгэнэ.Энэ сөхөрч сууж байгаад л өнөө өдрийнхөө заасан номыг цээжилнэ.Хэдэн цаас ном өгсөн байна, тэрнийг яг цээжээр шүүлгэнэ.Аа тэгээд болсон болвол тэр , болоогүй болвол алга авна, хулс авна, ташуур авна.

Гантулга: Шийтгэлтэй?

Гэмбэл: Тийм.

Гантулга: Жоохон томхон болоод хорин хэд хүрээд ирэхээрээ?

Гэмбэл: Хорин эхд хүрээд ирэхээрээ биеэ даагаад явчихна л даа.

Гантулга: Хэдэн наснаасаа бие даах уу, ер нь?

Гэмбэл: За ер нь , арван гурав, дөрвөн наснаасаа биеэ даачихдаг юмаа.Би нэг зургаан настай суугаад, найман настай хангал чойжид дүүргэсэн хүн.Есөн настай данжиг, ламиран хоёр үзэж байлаа. Би арван настай Санжчогсомд бүрэн хурсан. Дүйнхороос бусдад нь хурсан.Чойрт ч хурчихсан, тийм хүн байлаа.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Одоо таны номнууд бүгд цээжтэй юу?

Гэмбэл: бараг цээжтэй гэж хэлж болохоороо.Одооны залуучууд судраар уншвал би цээжээр л гүвээд байна.

Гантулга: Та одоо биеэ дааснаас хойш сүсэгтнүүдтэй яаж харьцдаг байсан, ном гүрэм их тавьдаг байсан уу?

Гэмбэл: Гүрэм тавьж базаагагүй. Бид нар чинь одоо, томчуул л олон байсан юм болоод бид нар чинь жаал жуул муу сайн банди нар.Тийм юм хийж байгаагүй.Тэгээд л ядуу дунд ангийн лам гэдгийн эгнээнд л үлдчихгүй юу/инээв/

Гантулга: Хийдийн ойролцоо айл өрхүүд байсан уу, одоо янз бүрийн хар ажил хийдэг?

Гэмбэл: Байна аа байна.

Гантулга: Ямар ямар ажил хийдэг улсууд байх вэ?

Гэмбэл: Жанч, шанагач, тогооч гээд л ...Өө тэгээд л түлш зөөдөг ч хүн байна. Одоо гал зууханд ажиллдаг улс ч байна.Одоо тааруухан тааруухан тэгээд...Дөрвөн сэнжтэй, том зууханд суулгачихсан хөдөлж болдоггүй тийм зэс тогоонууд, голцуу хүрэл тийм тогоонууд байсан юм.Одоо Сайн бичигтэд чинь олон тийм тогоонууд байсан юм.Энэ Цэций дээр нэг зэс тогоо байсныг та үзсэн үү, дөрвөн сэнжтэй.Тийм, тэр л ирсэн юм.Тэр чинь ганжуур жасын тогоо, тэгээд цогчин жасын тогоо нь том, Чойрын жасын тогоо том.Тэр чинь...

Гантулга: Хэдэн хүний тогоо байх уу?

Гэмбэл: Аан?

Гантулга: Хэдэн ламын тогоо байх уу?

Гэмбэл: Таван зуун ламын тогоо хоёр зуун ламын тогоо хоёр зуун тавин ламын тогоо.

Гантулга: Сүм хийд, тэр Бичигтийн хийдийн ойрхон...

Гэмбэл: Дөрвөн тагтай.Дөрвөн талаас нь...тэр зуухан дээрээ гарч байгаад таглаж яадаг.

Гантулга: Хийдийн ойролцоо наймаа, зээлийн газар байсан уу?

Гэмбэл: За зээлийн газар гэж байгаагүй.Ер нь тэр үед чинь зах зээл ч гэж юм мэдэх байсан биш.

Гантулга: Гурил будаа тэгээд юмаа яах уу, жас нь л зохицуулах уу?

Гэмбэл: Аа жас нь л аваад байна. Хятад хийж ирээд байна.

Гантулга: Нүүдлийн хятад наймаа?

Гэмбэл: Тийм. Өөрснөө Шинди яваад үгүй бол Улаанбаатиар хот яваад л одоо тэмээгээрээ ачаад ачаад ирнэ.Жас чинь одоо арван тэмээ, хорин тэмээ унаж яваад л тэгээд л тэр хүрал хийдийнхээ бэлтгэлийг бүрэн аваад ирнэ шүү дээ, тэр нярав нар чинь?

Гантулга: Аа тэгээд жасаасаа гадна лам нар бас хувиараа гэр орондоо гурил будаа авна?

Гэмбэл: Тэгнэ ээ тэгнэ.

Гантулга: Жасаасаа л худалдаад авчихна?

Гэмбэл: Жас чинь бол лам нарт таваг, гүнцэг гээд л бүх юмыг чинь , иэдх уух юмыг чинь хангаад байна.Тэрүүгээр л идэж уугаад байна.

Гантулга: Тэр Шинди гэж та юу хэлсэн бэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гэмбэл: Одоо Бууч Шинди гэж Хятадын хот.

Гантулга: Энэ хэдэн онд та хар болсон гэлээ?

Гэмбэл: Гучин долоон онд.

Гантулга: Тэгээд л сүм хийд хаагдсан?

Гэмбэл: Тэгсэн.

Гантулга: Сүм хийд хаагаад яасан, дор нь нураачихсан уу, эсвэл...?

Гэмбэл: Өө нураачихсан нураачихсан. Түлэхийг нь түлээд л, өнөө хамаг бурхныг чинь аваачаад л одоо байшинд хийгээд л түлээд л ...

Гантулга: Ном судрыг нь ?

Гэмбэл: Ном судрыг нь дандаа түлээд л , шатаагаад л ...

Гантулга: Дуганы доторхи тэр олон чимэглэл?

Гэмбэл: Аа тэрнийг чинь хэрэгтэйг нь аваад л , мөнгөтэй цэнгэтэйг нь аваад л бусдыг нь түлээд байна даа.Тэр олон чамын сайхан баг, тэр олон сайхан шүүмал бурхан, тэр уран ламын гараар бүтсэн хичнээн их сайхан өв хөрөнгө байсан, лут юм байсан.

Гантулга: Лам нарын хөрөнгийг, олон лам нарын хөрөнгийг хураасан уу? Шууд барьж аваад л хураачихсан уу?

Гэмбэл: Аа урдаар барьж аваад л явсан. Тэгээд л гүйцэтгэчихсэн хойноо ирж аваад л өнөө лацдаад ломбодочихсон, байшинг нь лацдаж, ломбодож цоошилчихоод түлхүүрийг нь аваад ...Тэр сүм хийдийн жас нарын түлхүүрийг нь хурааж аваад.Тэр даа лам нярав нараас сүм хийдийн жас нарын чинь, тэр арван хэдэн жасын түлхүүрийг хураагаад...Нэг жасын түлхүүр гэдэг чинь ингээд багтахааргүй юм.Олон байшинтай, олон түлхүүртэй.Түлхүүрч гэж байна шүү дээ, жасын чинь. Түлхүүрч гэж хүн байдаг юм .

Гантулга: Хийдийн лам нарын ихэнх нь баригдсан уу?

Гэмбэл: Өө томчуул л баригдсан.

Гантулга: Хуу баригдсан?

Гэмбэл: Тэгсэн.

Гантулга: Тэгээд л дан багачуул, залуучууд үлдсэн?

Гэмбэл: Тэгээд л үлдсэн.Бид нэг хорин зургаан банди артелд орсон юм.

Гантулга: Тэгээд артелд орж үзээд?

Гэмбэл: Дөч хүрсэн ганц өвгөн, Чаграажаагийн дүү Лувсаншарав гэж байсан юм.Өвгөн байсан юм. Одоо энэ...

Гантулга: Бурхан шүтээн, ном судраа ер нь энэ тэнд нууж, авч үлдсэн юм байна уу?

Гэмбэл: Байхгүй шахуу юмаа.

Гантулга: Амжаагүй юу, ерөөсөө?

Гэмбэл: Тэгээд нэг хоёр хүн баахан юм хураасан байсан юм.Нэг өвгөн, нэг хөгшин хоёр. Тэгээд тэр хоёр тэр юмаа хаана хийчихсэнийг нь одоо болтол мэдэгддэггүй.

Гантулга: Одоо байгаа юу, тэр улсууд нь?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гэмбэл: Байхгүй. Өөд болсон.

Гантулга: Зүгээр ард улсууд байсан юм уу?

Гэмбэл: Ард улсууд байсан юм. Өлзий чавганц, Буд гэлэн гэж хоёр хүн байсан юм.

Гантулга: Тэр лам нарыг яаж хэлмэгдүүлж байсан бэ, аваачаад шууд цаазаар аваад хаячихаж байсан уу?

Гэмбэл: Аа тэгээд л барьж аваад л , шууд ерөөсөө чамайг баривчиллаа гээд л...Тэгээд л бүсийг нь аваад л , чамайг барилаа гээд л ...

Гантулга: Нимгэн дээлтэй?

Гэмбэл: Нимгэн дээлтэй.Тэгээд л аваачаад л энэ юуны ...Шанхайн тамга гэж зүүнтээ одоо эндээс нэг гучаад км газар Шанхайн тамга гэж байсан юм . Тэрүүн дээр анхны шав нь тэр шорон барьсан юм.Ганц улаан байшин байсан юм ш дээ. Тэгээд тэрүүнд л дүүргээд л .Багтаж өгөхгүй , өнөө лам нар нь .Тэгээд л нэг тэмээнд хоёрыг мордуулаад л тэгээд л туугаад л тэгээд л аваад явсан. Үнэхээр өөрийн эрхгүй, үнэхээр хэлмэгдүүлсэн.

Гантулга: Тэгээд нэг ч хүн эргэж ирээгүй?

Гэмбэл: Ирээгүй.

Гантулга: Аймаг руу аваад явсан, ямар хүн тэр үед энэ баривчилгааг нь хийж байсан юм бол?

Гэмбэл: Өө энэ тэнд бол олон хүн байсан л даа.Манай энд бол харин гол юмыг нь бол Шууз, Лувсан гэж хоёр хүн л...

Гантулга: Энэ нутгийн улсууд уу?

Гэмбэл: Тийм.

Гантулга: Тэр хоёр л гардсан?

Гэмбэл: Шууз гэдэг чинь одоо Идэрийн ах нь.Дамирангийн Шууз гэж байсан юм. Одоо муу маамаатай байсан хүн дээ. Төмөртоогоогийн эцэг.Шууз гэж, хүнхэр Шууз гэж байсан юм. Дотоодын яамны хүн.

Гантулга: Лувсан гэдэг нь?

Гэмбэл: Лувсан гэдэг нь одоо Жанчив багшийн ах ,одоо Чойцэрэнгийн ах.

Гантулга: Та тэр ном судраа унших, сүсэгтэн олондоо шашин номынхоо талаар тус болж байсан уу?

Гэмбэл: Чадаагүй. Би чинь МАХН-ын гишүүн. Зайлуул, жаран оны гишүүн.Бас улаан хувьсгалч нэртэй. Тэгээд...

Гантулга: Нууцаар ном момоо уншдаг байсан юм биш үү?

Гэмбэл: Тэгээд л энэ ойр зуурын номнуудыг бол одоо бичдэг. Энэ Жанлавцогзол гэж та нар зөндөө дуулаа биз дээ?

Гантулга: Дуулсан дуулсан. Өндөр гэгээний зохиосон?

Гэмбэл: Тийм тийм.

Гантулга: Та тэрнээсээ уншиж өгөөч?

Гэмбэл: Жанлавцогзол уу?

Гантулга: Тийм, энэ сайхан уншаад хураалгачихая.

Гэмбэл: Жанлавцогзол ганжид дамаа лан гадив чүйнхор ядам шотой лан

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гажид дүйсэр хантай чойжид хантай гацан үүхай жамбал чанцай дог
Ваший ирдэ гашив ширда сон үхай ваший ширдал намахай цэрдэн ганши
Тогмид наший дүгдэн шарши нонжин хөгчи гялай дан
Савжа чээжээ хорло гурвар хорло солдо даншиг солой
Дачин малий гэгэ хумбай намдаши шалжи даший лүн
Доогон маариг манга гүнсэл дэгүнчиг нэчэ нагваан чойжил
Цэдэр манчин лхагвар дүвой давжид дүйнхор доло дүгжи
Даагин жиман марва дүнжи дүмбэ нацаг дүйвон начи
Ханчин гамбар жүндий янтин нидалиг гүвор цог
Цовжид цогчиг лүво мэди дэвон согшиг цэршиг
Цадмид дүгжи нигэл наяг наяг гонжи түгдэн жон
Гочин донжи нирваан нидав жалдан жигмад цагчир живаа дин
Ноогүн дэгжид наваа дин дэчин цогчиг гүнчэн наваа
Дэчин норово нэчид рэгжид лама чогсон дамбий чогсод дан
Чойрон шимбэрэл дэмбэрэл мэдсод чойсэрэн дамжа жи
Жагван дүва лама найгад тортог гүдма гүнши

Сэрдэн шивий лэгцэг лүнлов пунцаг вала далбий даший чо. За одоо энэ дайн дажингүй байх гэсэн ийм утгатай, өндөр гэгээн Занабазар зохиосон Жанлавцогзол гэдэг ном.Энүүнийг бол одоо энэ л манай төрийн дээд улс чинь одоо тангараг өргөхийнхөө өмнө уншдаг, уншуулдаг.

Гантулга: Өмнө нь , урд нь ?

Гэмбэл: Тийм. Амгалан тайван, энх түнх, эрүүл саруул явах ийм зорилготой ном шүү дээ.Гол нь болвол дайн дажингүй явах.Тэгээд би энэ Жанлавцогзолыг чинь уул нь тэгж дуулсан зүүн хязгаарт очоод л , юмуу эндээс өмнөговь явахдаа Жанлавцогзолоо уншаад л цохиж л байлаа.

Гантулга: Тэгээд л амьд хүрээд ирсэн, буцаад л ?

Гэмбэл: Тийм, дажгүй ээ/инээв/

Гантулга: Энэ суман дээр байгаа хийд чинь сайн бичигтээ сэргээчихээд байгаа юу, эсвэл зүгээр өөр шинэ сэргээсэн ?

Гэмбэл: Шинээр л одоо бариад сэргээчихээд байгаа.

Гантулга: Тэрнээс бол тэр Сайн бичигтийн шүтээн мütээн тэнд бол байхгүй юу?

Гэмбэл: Байхгүй байхгүй. Тэндээс болвол бурхан багштай, богд Зонхов бурхныг нэг тэртээ Бээжингээс хэн залж авчирч өгсөн, сая гаруйгаар...Амарболд.

Гантулга: Аан Амарболд, цагдаагийн дарга?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гэмбэл: Тийм , дарга байсан.Амарболд. Амарболдын чинь эцэг манай Цэцийн хүн.Үндсэн нутаг нь.Алтан-Очир манай Цэцийн хүн, үндсэн нутгийн хүн. Манай энэ хийдэд гар бие оролцож байсан тийм сайн сайхан улсууд байна.Хойно одоо Дэндэнгийн Буд гэж хүн бий.Манай уугуул иргэдийн дарга байсан. Таних уу?

Гантулга: Одоо дуулсан л хүмүүс байна.Алтан-Очир гэдэг чинь ямар хүн бэ?

Гэмбэл: Одоо Чойжамцын...

Гантулга: Тамгын газрын дарга байсан уу?

Гэмбэл: Тийм, тамгын газрын дарга байсан.

Гантулга: Аан Гандантэгчилэн хийдийн тамгын лам?

Гэмбэл: Тийм.

Гантулга: Танина аа танина.

Гэмбэл: Алтан-Очир. Жинхэнэ манай эндхийн хүн.Энэ Баруун Суугийн хурал бол Манал Оточ шүтдэг.Ер нь эмийн талын гол юм шүтдэг.Дарь эх, Манал хоёр шүтдэг тийм газар байсан юм.

Гантулга: Олон ламтай байсан уу?

Гэмбэл: За даа , нэг хорь гучин лам тогтмол.За тэрнээс илүү ч нээх байгаагүй ээ дээ.

Гантулга: Ер нь хэдий үед байгуулагдсан хурал вэ?

Гэмбэл: Аа энэ Сайн бичигтээс сүүлд байгуулагдсан хурал.

Гантулга: Сайн бичгээс сүүлд байгуулагдсан юм уу?

Гэмбэл: Сүүлд байгуулагдсан.

Гантулга: Ямар хүн байгуулсныг нь дуулаагүй биз?

Гэмбэл: За ер нь бараг энэ Нурдан тайж гэдэг үеийн л юм болов уу.

Гантулга: Нурдан...?

Гэмбэл: Нурдан тайж.

Гантулга: Энэ Говь Түшээ гүний засаг байсан хүн үү?

Гэмбэл: Тийм, энэ...Дайчингийн хишиг гэж байсан юм.

Гантулга: Хишиг ээ?

Гэмбэл: Тийм, Хишигийн ноён.Нурдан тайж гэдэг чинь.

Гантулга: Тэр бусад хуралтайгаа, Сайн бичигтдээ захирагддаг байсан уу, ямар харилцаа холбоотой байсан?

Гэмбэл: Өө мөн яг эндэ, эндээсээ , тэндээсээ дэглүүлээд...

Гантулга: Сайн бичигтээсээ?

Гэмбэл: Тийм, энэ ер нь Говь түшээ гүний хийдүүдийн чинь тэр Хошуу хийдээс л голцуу чиглэсэн юм л даа.

Гантулга: Одоо энэ Онгийн хурал?

Гэмбэл: Тийм, Онгийн хурал. Тэр чинь Хошуу хийд байсан юм.Хамгийн тэргүүн хийд нь.

Гантулга: Тэрнээс хойш л байгуулагдсан хийдүүд?

Гэмбэл: Тийм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Бас л шарын хурал байсан уу?

Гэмбэл: Тэгнэ ээ тэгнэ.

Гантулга: Олон дацан дугантай байсан болов уу?

Гэмбэл: Өө энэ чинь хоёр гуравхан дугантйа байсан юм.

Гантулга: Өдөр бүрийнх нь хурал ямар хурал байсан юм бол?

Гэмбэл: Ядам байсан юм . Манал байсан юм .За чухам гол сахиус нь тэр юу байсныг сайн мэдэхгүй юм аа. Тийм л газар даа , гол сахиус нь ...

Гантулга: Оточ манал байсан юм болов уу, манал хурдаг байсан болохоор?

Гэмбэл: Үгүй ээ, манал ч байгаа л даа.Энэ арван хангалаас нэгийг нь шүтэж байсан байгаа даа .Тэгэхдээ ер , чамтай л байсан болов уу даа.

Гантулга: Дацан сургуультай байсан уу, энэ эмнэлгийн сургууль? Мамба дацан?

Гэмбэл: Тийм. Мамба дацан, Найдан дацан дандаа дацан хурлууд шүү дээ.

Гантулга: Зурхай, өөр Жүд, Дүйнхор эд нар байсан болов уу?

Гэмбэл: Хаана, энд үү?

Гантулга: Тийм.

Гэмбэл:Байгаагүй ээ, байгаагүй.

Гантулга: Том эрдэмтэй, орон хийдийнх нь том лам нь ?

Гэмбэл: Балдан цорж, Лувсан цорж хоёр хүн байсан юм.

Гантулга: Аа том лам нь?

Гэмбэл: Тийм.

Гантулга: Дандаа цорж, маарамба үлсүүд уу, эд нар?

Гэмбэл: Тийм.Маарамба эмч нар.

Гантулга: Зурхайч нар?

Гэмбэл: Нэг зурхайч гэж, Дэчин гэж нэг хүн байсан юм.Цантуузын дэчин гэж, Балдан цоржын шавь.Тэр зурхай зурдаг хүн байсан юм.

Гантулга: Хийдийнх нь туурин дээр очсон чинь сүм байсан гэж айн мэдэгдэхээргүй болчихсон байна лээ.Янз бүрийн байшин барилга бариад?

Гэмбэл: Тийм. Сургууль цогчин дуганд нь байсан юм.Ядмын дуганд нь гар үйлдвэр байсан юм.Дарь эхийн дуган гэдэгт нь сумын захиргаа байсан юм.За ийм л гурван дугантай байсан юм даа. Лувсан цорж гэж нэг их сайн эмчлээгүй. Тэрний анхны лам нь Уваан лам гэж ловон байсан юм даа.

Гантулга: Аа мөн, Уваан лам ?

Гэмбэл: Уваан лам гэж.

Гантулга: Анхных нь цорож уу?

Гэмбэл: Тийм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Энэ таныг байхад байсан хүн үү?

Гэмбэл: Тэгээд дараа нь Балдан цорж гэж. Балдан цорж нь болсон юм. Балдан эмч.

Гантулга: Бас л гучин долоон онд хаагдаад?

Гэмбэл: Тэгсээн тэгсэн.

Гантулга: Тэгээд л байхгүй болсон , тиймээ?

Гэмбэл: Тийм, тэгсэн. Тэгээд сумын захиргаа байрлаад байж байгаад нүүгээд одоо...Хийд бол цаньд чойр голлодог, олон гэвш нартай.

Гантулга: Ямар игчаатай байсан бэ?

Гэмбэл: Гүнчин игчаа. Ер нь Банчин игчаа манай энд байгаагүй юм.

Гантулга: Сэр исчаа байсан үү?

Гэмбэл: Гүнчин, Банчин игчаа л гэж байсан юм.Гүнчин игчаа байдаг юм.

Гантулга: Өр тэгээд Олдохын хийдийн талаар, орон хийдийнх нь эзэн лам?

Гэмбэл: Аа Аранжамба лам гэж байсан юм, жинхэнэ эзэн нь байсан юм.

Гантулга: Аранжамба лам.

Гэмбэл: Олдохын Аранжамба лам гэдэг чинь их том хүн байсан юм.Тэр хийдийн эзэн.

Гантулга: Энэ хүн бол хувилгаан хүн байсан үү?

Гэмбэл: Аа тийм, Аранжамба хүн байсан юм .

Гантулга: Цол нь ?

Гэмбэл: Тийм цол нь .

Гантулга: Олон ламтай байсан үү?

Гэмбэл: Аа нэг хоёр, гурван зуугаад лам байсан.

Гантулга: Хэдэн дугантай байсан?

Гэмбэл: Дуган ер тав , зургаан дуган байсан. Би очиж хурж л байсан. Бичигтэд хүрдэггүй юмаа.

Гантулга: Арай Бичигтэд хүрэхгүй?

Гэмбэл: Цаньд Чойр...

Гантулга: Налихын хийд?

Гэмбэл: Налихын хийд чинь хоёр гуравхан дугантай байсан юм.

Гантулга: Хийдийн эзэн лам нь ямар хүн байсан бэ?

Гэмбэл: Жамбал ловон гэж байсан юм. Жамбал гэсгүй...

Гантулга: Хэд орчим ламтай байсан юм?

Гэмбэл: Аа нэг гуч, дөчөөд ...Цагийнхаа хурлаар нэг дөч, тавь хүрч байсан юм уу, үгүй юм уу.

Гантулга: Гол шүтээн нь?

Гэмбэл: Аан , хэний Налих үү?

Гантулга: Гол шүтээн нь , Налихын?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гэмбэл: Налих ер ...Юу байсан. Намсрайжамц гэж шүтэж байсан байх.

Гантулга: Оолдохын хийд?

Гэмбэл: Олдохын хийд...Жамсран шүтэж байсан байх.

Гантулга: Сангийн далай хийд?

Гэмбэл: Сангийн далай хийд ч ...за сайн мэдэхгүй юм. Гомбо л шүтэж байсан байгаа даа.Гомбыг ер нь гол газар Гомбоо шүтэж байсан ш дээ, Гомбо Гонгорыг.

Гантулга: Ерөөсөө томууд нь ?

Гэмбэл: Лам Чойжоо тэгээд энэ хэдийг л ...Тэгээд Жамсран, Намсрай.

Гантулга: Цөөхөн ламтай байсан юм байна ш дээ, тиймээ?

Гэмбэл: Тиймээ тийм.

Гантулга: Жижигхэн хурал байсан юм байна ш дээ, тиймээ?

Гэмбэл: Барагтай л ...зуу, зуу хүрч байсан байх даа, юундаа.Би Сангийн далай очиж хурж байгаагүй.Тэрийг би сайн мэдэхгүй. Хошуу хийд ч олон ламтай байсан.

Гантулга: Хошуу хийд бол олон ламтай байсан гэж үү?

Гэмбэлд: Тэгсэн.

Гантулга: Эхэн заг дээр бол очиж байгаагүй, тиймээ?

Гэмбэл: Аан Эхэн заг дээр бол би очиж байгаагүй.

Гантулга: Тэр Улаан эрэг гээд цаана нь нэг хурал байна лээ?

Гэмбэл: Улаан эргийн хурал.

Гантулга: Тэнд очиж байгаагүй юу?

Гэмбэл: Үгүй.

Гантулга: Дуулсан уу, та ер нь?

Гэмбэл: Би дуулсан дуулсан.

Гантулга: Тэдэн ламтай, тийм ламтай...?

Гэмбэл: Үгүй ээ. Ер нь энэ Эхэн заг л хамгийн том.

Гантулга: Хамгийн том?

Гэмбэл: Сангийн далай хоёр л.Овоо ламтай, тэгээд хурлаа дандаа хоёр хийд нийлж хийдэг.

Гантулга: Эхэн заг үү?

Гэмбэл: Тийм. Эхэн заг , Сангийн далай хоёр чинь нэгдэж хурлаа хийдэг.

Гантулга: Нэгэн дээрээ цугладаг гэсэн үг үү?

Гэмбэл: Тэгсэн үг.

Гантулга: Нэгэн дээрээ хурлаа хийгээд л , нөгөө талын лам нар ирээд л цуг хурчихдаг?

Гэмбэл: Тийм тийм.

Гантулга: Тэгээд л солиод явдаг?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гэмбэл: Тийм. Ухаан нь бүл муутай л байсан ...

Гантулга: Хошуу хийдийнхээ талаар?

Гэмбэл: Хошуу хийд бол том бие даасан, том хийд ээ.

Гантулга: Гол шүтээн нь ?

Гэмбэл: Гол шүтээн нь Гомбо оо.

Гантулга: Хэд орчим ламтай байсан юм?

Гэмбэл: За ер нь нэг гурван зуу, дөрвөн зуу орчим хүнтэй байсан байх аа.

Гантулга: Хэдэн дацантай байсан юм?

Гэмбэл: Дацан сайн мэдэхгүй юм аа. За байз аа...Мамба дацантай байсан, Жүдтэй байсан.

Гантулга: Чойр?

Гэмбэл: Чойртой байсан. Чойр болвол бүр анхны Чойр л доо, манай Өмнөговийн. Тэгээд Олдох. Олдох ч Цаньдын талаар бол овоохон ч их нгэртэй , овоохон ч царгиж байсан газар даа. Энэ гурван газар бий.

Гантулга: Олдох , нэг нь юу билээ?

Гэмбэл: Далайн хурал.Энэ Хөнжлийн далай гэж байсан юм.Манай зиндааны жорвон Бүлтүүш гэж хүн байсан. Юм.

Гантулга: Энэ Бичигтийн хийдийн чинь жорвон ямар хүн байсан юм?

Гэмбэл: Манй зиндааны жорвон бол Жамъяншарав гэж хүн байсан юм. Саяхан нас барса, надтай цуг ямаа маллаж социлист хөдөлмөрийн бригадад ажиллаж байгаад. Тойдуудын хийд гээд бүр Бичигтийн түрүүнд байгуулагдсан хийд.

Гантулга: Өө тиймүү, Тойдуудын хийд ээ?

Гэмбэл: Тийм, Тойдуудын хийд.Гурван газар нүүгээд байгаа юм. Элгэний эхэн дээр анх тэрэн дээр Тойдуудын хийд байгуулагдаад, Сайн дэрсэн дээр очиж байж байгаад тэгээд Лүн дээр очсон юм.Тэгсэн юм , гурав нүүгээд байгаа юм. Тийм хочр нүүгээд, гурав дахь дээр нь...

Гантулга: Лүн гэдэг нь газрынх нь нэр юм байна тиймээ?

Гэмбэл: Тийм, овоо.Тахилгат овоо.Нэг ядам, цогчин хоёроос илүү юм байхгүй.

Гантулга: Одоо энэ Говь түшээ гүний дөчин хэдэн хурлаас нэрлэвэл, та санаанд байгаагаа?

Гэмбэл: За тэгээд л тэр Сангийн далай, за тэгээд л тэр Долоон сүмийн хийд, долоогийн хийд гэж байсан.Энэ Налихын хийд гэж байсан. Дөчийн хийд гэж байсан.Лүнгийн хийд гэж хэлчихсэн билүү.Хойшоо явбал Далайн хурал, Хошуу хийд, Олдох, за тэгэд Аврах, Билүүн...

Гантулга: Билүүн?

Гэмбэл: Билүүн. Тэгээд чинь дээ, за байз Байшинт...

Гантулга: Цохиот?

Гэмбэл: Тэгээд л Галдын гурван хийд байлаа.Аа нэг ийм л хийдүүд байсан юм даа. Дүнгэл гэдэг юм. Тойдуудын хурлыг.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Гол том нь?

Гэмбэл: Аан?

Гантулга: Бусдыгаа удирддаг гол том нь?

Гэмбэл: Хошуу хийд.Энэ дээрх орчиндоо бол Бичигт.

Гантулга: Хамгийн сайн Чойртой газар нь ?

Гэмбэл : Хамгийн сайн Чойртой газар нь Олдох.Олон гэвш нартай.

Гантулга: Эм зурхай мамба нь болохоор?

Гэмбэл: Мамба ч голлож байсан юм нь , за Баруун сууг тавьчихаж болох юм.Баруун суу бол хоёр эмч л голлож байсан газар л даа.

Гантулга: Жүд?

Гэмбэл: Жүд болвол за тэгээд хаа сайгүй л дээ.

Гантулга: Бичигт?

Гэмбэл: Бичигт болвол энэ Түшээ Гүний дөчин хэдэн хийдүүдээс үлээгүүр , уншлага бүх юмаараа тэргүүлж байсан газар.

Гантулга: Үлээгүүр уншлага, өөр?

Гэмбэл: Өөр тэгээд л цам ном...

Гантулга: Чойр?

Гэмбэл: Чойр . Чойр ч яахав дээ, дунд зэрэг л байсан.

Гантулга: Цам ном юу гэнэ ээ?

Гэмбэл: Одоо энэ хавьд ийм хоёр өдрийн цамтай газар байгаагүй юм шүү. Бусад газар.

Гантулга: Үлээгүүр уншлага, цам ном?

Гэмбэл: Тийм .Цагар, чугар тэгээд сачиг, дүлцон. Байгаагүй юм байхгүй. Лам нар нь дандаа сайн уншаач, дандаа сайн үлээгүүрч. Тийм газар, этгээд газар байсан юм даа.

Гантулга: Энэ Долоогийн сүм бас нэлээн том байсан уу?

Гэмбэл: Барагтай багаахан байсан.

Гантулга: Багаахан байсан уу?

Гэмбэл: Багаахан байсан.

Гантулга: Одоо энэ Баян –Овоогийн сумын төв дээр байгаа тиймээ?

Гэмбэл: Тийм.

Гантулга: Тэргүүн нь ямар хүн байсан юм бол?

Гэмбэл: Хорол ловон гэж байсан юм, сүүлрүүгээ байсан юм.

Гантулга: Энэ олон ламтай хийд байсан уу?

Гэмбэл: Аа даа нэг зуу дотор л багтаж байсан байх даа.

Гантулга: Бас л шарын хийд үү?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гэмбэл: Тийм ээ тийм.

Гантулга: Чойр дацантай байсан уу?

Гэмбэл: Энэ Долоо юу, Долоо чинь Чойр байгуулаагүй.

Гантулга: Хэдэн дацан дугантай , суваргатай байсан юм бол?

Гэмбэл: Долоо юу, ер сайн мэдэхгүй юм аа. Би ч нэг очих нь очиж байсан.Тэгээд л нэг сондуулын зах дээр жоохоон л хийд байсан даа.Хорол ловон гэж байж байгаад, Норов гэж байж байгаад , Шар Норов гэж байж байгаад тэгээд өнөө муу Шар Норов чинь Долоогийн сүмийн үнзад байсан юм. Хоролын шавь. Одоо чинь төв хийдээс гэхээс л хурал ч гайгүй л хурдаг.Тэгээд Долоон сүм ч бас, Бага мод гэж байсан юм. Долоон сүмээс өмнө. Бага нартын хийд гэж нэг хурал байсан юм.

Гантулга: Хаана байсан юм?

Гэмбэл: Тэрүүхэн Долоон сүмээс зүүнхэн урд, тэр юуны...

Гантулга: Тэр сондуул дотор байсан юм уу?

Гэмбэл: Тэгээд тэр Равзан Дашзэвэгийн хочд энгэрт Толь Булгаас нааш гэж.

Гантулга: Бага модын хийд хэр том хийд вэ?

Гэмбэл: Өө жижигхэн жижигхэн.

Гантулга: Тэр Уртын хурлыг тэргүүлж байсан тэр эзэн лам нь ямар хүн байсан юм, та мэдэх үү?

Гэмбэл: Уртын хурлын Эрдэнэ гэж хүн байсан хүн юм.

Гантулга: Хамба гэж ярих юм уу, ловон гэж ярьдаг юм уу?

Гэмбэл: Үгүй одоо тэр чинь нэг гэртэй , дуган гэж ч юм байхгүй. Уртын хурал байгуулаад.Найзын хурал ч гэдэг юм уу, Уртын хурал ч гэдэг юм уу.Эрдэнэ гэж нэг эм зэм барьчихдаг.

Гантулга: Тэр аль хийдээсээ тасарч гарсан юм ?

Гэмбэл: Аан?

Гантулга: Аль хийдээсээ тасарч гарсан юм ?

Гэмбэл: Одоо энэ Бага нартаасаа л тасарч гарсан байх.

Гантулга: Бага мод нь том хийд байсан юм уу?

Гэмбэл: Бага мод нь арай том.Долоо, Бага мод гэж хоёр хийд байсан юм.

Гантулга: Тэгээд Долоо сүм нь голлож байсан юм уу, Бага мод нь..?

Гэмбэл: Долоо мод нь голлож байсан юм.

Гантулга:Аа тэгээд Долоогийн л дагавар хийд байсан юм уу?

Гэмбэл: Тийм.

Гантулга: Бид нар дараа танаас ирж илүү их ярилцлага авмаар байна аа.

Гэмбэл: За за.

Гантулга: Дараа ирж.За маш их баярлалаа.

Гэмбэл: Би ч одоо мунхарсан хүн. Хэрэг байхгүй.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Гэхдээ сайхан ярьж байна аа , та. Хуучнаа мартаагүй байна. Маш сайхан ярьж байна.

Гэмбэл: Хоёр хөл гишгэхээ байсан. Хоёр нүд юм үзэхээ байсан.